

Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

2016 оны 5-р сар

Хэрэгжүүлэгч:



Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө
фермерүүдийн холбоо ТББ

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

МОНГОЛ НОГОО – ХҮНСНИЙ НОГООНЫ ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, МАРКЕТИНГИЙН ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Монгол ногоо - Хүнсний
ногооны тогтвортой үйлдвэрлэл,
маркетингийн төсөл

Хугацаа:

2016 – 2019

Төсөв:

5.0 сая шв. франк

Зорилтот бүлэг:

- Бага талбайд хүнсний
ногоо тариалдаг ногоочид
болон хүнсний ногооны үр
үйлдвэрлэгчид
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт
хотуудын гэр хорооллын өрхүүд

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд

- Монголын фермер
эмэгтэйчүүдийн холбоо ТББ
- Дэлхийн Хүнс хөдөө аж ахуйн
байгууллага (ДХХААБ)



Ургац хураалт. Сэлэнгэ аймгийн Мандал сум.

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт эдийн засагт шилжсэний дараа уналтанд орсон газар тариалангийн салбар эргэн сэргэтлээ нэлээдгүй жилийг зарцуулж байна. Тариалалт, хэрэглээ тогтмол нэмэгдэж ирсэн хэдий ч хүнсний ногооны үйлдвэрлэл дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй, БНХАУ-аас импортоор хүнсний ногооныхоо 40 хувийг хангаж байна. Монгол Улсын Засгийн газар уул уурхайн салбарыг тэргүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжлийн нөөц хувилбар гэж үзэж байна. Хүнсний ногооны үйлдвэрлэл, хадгалалт, дахин

боловсруулалт, маркетинг болон бодлого зохицуулалт зэрэг бүх шатанд шийдвэрлэж болох тулгамдсан асуудлууд байгаа нь нөгөө талаасаа ногоочдын амьжиргааг дээшлүүлэх, дотооддоо тариалсан ногоог хүнсэндээ хэрэглэх нөөц бололцоо байгааг харуулж байна. “Монгол ногоо” төсөл нь Швейцарийн хөгжлийн агентлагаас Монголын төмсний салбарт үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд гарсан амжилт дээр тулгуурлан, Монгол орны хүнсний ногооны салбарын хөгжлийг дэмжих замаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахыг зорьж байна.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ЗОРИЛГО

Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулах

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД:

- **Зорилт 1:** Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Бага талбайд ногоо тариалдаг тариаланчдад тулгамддаг асуудлууд болох хямд үнэтэй, орон нутгийн онцлогт дасан зохицсон сортын ногооны үрийн олдоц, тоног төхөөрөмжүүдийн хангамжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн болон ургамал хамгааллын талаарх зөвлөмж, сургалт явуулах, ногоочдын бүлэг хоршоодын чадавхийг сайжруулахад энэхүү үйл ажиллагаа чиглэгдэнэ. Эдгээр дэмжлэг нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлээд зогсохгүй бүтээгдэхүүний гарц, чанарыг нэмэгдүүлж мөн хэрэглэгчдийн таашаалд нийцсэн ногоо худалдаанд гарахад томоохон түлхэц болно.
- **Зорилт 2:** Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна. Зохион байгуулалтанд орсон ногоочид болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж итгэлцэлд суурилсан тогтвортой харилцааг бүрдүүлсэнээр ногоочдын борлуулах ногооны үнийг бодитой, тогтвортой болоход энэхүү үйл ажиллагаа чиглэгдэнэ. Эдгээр дэмжлэг нь ногоочдын байгууллагуудад чиглэсэн технологи, маркетинг, бизнесийн удирдлага, зах зээлийн мэдээллийн сургалтууд болон зоорь, дахин боловсруулах чиглэлийн санал санаачлагуудыг дэмжих, мөн хэрэглэгчдийн хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалт, сурталчилгаанууд байх юм.
- **Зорилт 3:** Хотын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны

тариалалтаар нэмэгдүүлсэн байна. Хөдөө орон нутгаас томоохон хотуудын гэр хороололд шилжин ирж суурьших иргэдийн тоо нэмэгдсээр байгаа өнөө үед иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх амьдралын арга барилын нэг хэсэг нь хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээ, зах зээлийн чиглэлээр мэдлэг олгох үйл ажиллагаа байж болно. Үүнийг сонгогдсон бүс нутагт бүлэг, нөхөрлөлд суурилсан аргачлалаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг сурталчлах, мэдээллийг түгээх аяны ажлууд зохион байгуулах, багаж, тоног төхөөрөмж, усалгааны системээр хангах байдлаар дэмжиж ажиллана.



Хүнсний ногооны зах. Дархан-Уул аймаг.

- **Зорилт 4:** Хүнсний ногооны салбарын бодлого, хууль эрх зүйн орчин сайжирсан байна. Хүнсний ногооны сорт, үр, ургамал хамгааллын тухай холбогдох хуулийн заалтууд шинэчлэгдээгүй эсвэл хуулинд тодорхой тусгагдаагүй байдаг тул үүнийг олон улсын стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэхүү шинэчлэл нь нэг талаас Монголын бүтээгдэхүүнийг экспортлоход дэмжлэг болох ба нөгөө талаас хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд томоохон хувь нэмэр болох юм. ХХААЯ-наас хэрэгжүүлж буй ургамал хамгааллын цогц менежмент ба органик тариаланг дэмжих санаачлага, туршилтын төслүүдийг үргэлжлүүлэн дэмжиж ажиллана.

Монгол төмс хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хүнсний ногооны сорт сорилтын ажлын (2012-2015) гол үр дүн, амжилтаас:

- Сорт сорилтоор хүнсний ногооны 34 зүйлийн 144 шинэ сортыг сорилтонд туршлаа.
- 2014 онд Улсын сорт сорилтын комиссоос хүнсний ногооны 7 зүйлийн 13 сортыг, мөн 10 эрлийз сортыг ирээдүйтэй сортоор батлаж, Монголд тариалахыг зөвшөөрлөө.
- Хүнсний ногооны үрийн дэлгүүрийг 5 аймгийн 8 суманд байгуулж, хүнсний ногооны үрийг тариаланчдад боломжийн үнээр нийлүүлж байна.

Хамтран ажиллагч байгууллагууд:

- Хүнс, хөдөө аж ахуйн яам
- Улаанбаатар хотын захиргаа, дүүргүүдийн захиргаа
- Орон нутгийн захиргаанууд
- Ургамал газар тариалангийн хүрээлэн
- Ургамал хамгааллын хүрээлэн
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Бүх Оросын хүнсний ногооны селекция, үрийн аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн
- Хандивлагч байгууллагууд / Олон Улсын ТББ-ууд: АХБ, КОЙКА, IFAD, АДРА, Дэлхийн Зөн, GERES, Caritas
- Хотын засаглалыг бэхжүүлэх төсөл, Улаанбаатар хотын захиргаа (ШХА)
- Мэргэжлийн боловсрол, сургалт төсөл II үе шат (ШХА)
- Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төслийн сонгогдсон дүүргүүдийн гэр хорооллын цэцэрлэг, сургуулиуд (ШХА)
- ЕХ / ДХХААБ-ын Ажлын байрыг дэмжих төсөл

Холбоо барих: МХШТФХ

Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны байр 207 тоот, Энхтайвны өргөн чөлөө 18а-1, Баянзүрх дүүрэг

Ш/Х 276, Улаанбаатар 13381, Монгол улс

Утас: +976 11 464 132, 460 158
Факс: +976 11 460 158 – 15
И-мэйл: contact@mfard.mn
Вэб хуудас: www.mfard.mn

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай Плаза Бизнес төв, Олимпын гудамж 12, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210, Монгол улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia